



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар АИЗ

Мандалговь

Ламхай хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл
байдлын үнэлгээ хийх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.4 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Энэтхэг улсаас тусгай үүргийн нислэгээр ирсэн Дундговь аймгийн Өндөршил сумын харъяат ламхай Цэрэндэжидийн Эрдэнэчулуун болон түүний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд, гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 293 590 (Хоёр зуун ерэн гурван мянга таван зуун ер) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190115